Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Хишигбаатар Саруул

# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлнэ. | | | | | | | |
| 1 | Жагсаалтад туссан төслөөс ТХААГ-аас тендер сонгон шалгаруулж, шалгарсан компанитай Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна. | Байгуулсан гэрээний тоо /тоо/ | Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан байна. | Төсөл хөтөлбөрийн Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан байна. /130 төсөл/ | 2024 оны байдлаар "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /улсын хэмжээнд/"-ын хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу холбогдох гэрээнүүдийн төслийг боловсруулсан. Тухайлбал: 1."Засгийн газрын XI байрны 1 болон 10 дугаар давхрын зарим, 2,3,4,11,13 дугаар давхрын их засварын ажлын зураг төсөв | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

287

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулах” зөвлөх үйлчилгээний гэрээ 2. 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 22-р хороо, 122 дугаар сургууль/ 3. Говийн бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төвийн ТЭЗҮ, зураг төсөл /Дундговь, Адаацаг сум/ 4. Хөдөө аж ахуй, Мал эмнэлгийн газрын барилгын зураг төсөл /Завхан, Улиастай хот/ 5. 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв, 320 суудал /Улаанбаата, Баянгол дүүрэг, 18 дугаар хороо, Оюуны ундраа цогцолбор сургууль/ 6. 3 ээлжээр хичээллэж байгаа Сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Баянзүрх цогцолбор сургууль/ 7. 3 ээлжээр хичээллэж байгаа Сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр хороо, 123 дугаар сургууль/ 8. Төрийн захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолборын зураг төслийн техникийн тодорхойлолт 9. Цэцэрлэгийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв 240 ор /Улсын хэмжээнд/ 10. Цэцэрлэгийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв 150 ор /Улсын хэмжээнд/ 11. Сургуулийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв 640 суудал /Улсын хэмжээнд/ 12. Дотуур байрны барилгын жишиг нэг маягийн зураг төсөв, 160 ор /Улсын хэмжээнд/ 13. Хилийн боомд дэд төслийн хүрээнд хийгдэх ТЭЗҮ, барилга байгууламжийн зураг төсөл (Бага-Илэнх боомт) /Булган, Тэшиг сум/ боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээнүүдийг тус тус боловсруулж байгуулсан бөгөөд дээрх гэрээт ажлуудын гүйцэтгэлийн явц хэвийн байгаа болно. | | |
| 2 | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр | Төслийн тоо/ тоо/ | Албан тушаалтны гарын үсгээр баталгаажих | Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын | 2024 оны байдлаар байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р | 100% |

283

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг хянана. | | шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан. | үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/ | үсгээр баталгаажих гадагшаа чиглэсэн 67 (үүнээс 8 нь ЗГХЭГ-ын холбогдох албан хаагчдад албан ёсны цахим шуудангаар нь албан бланкаар бус PDF файл-аар албан бичиг боловсруулж хүргүүлсэн болно) албан бичгийн төсөл, бусад нэгжүүдэд чиглэсэн 50 дотоод бичгийн төсөл болон нууцын бичгийн төслүүдийг (боловсруулсан нууцын бичгийн төслийн тоо нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар нууцын зэрэглэлд хамаардаг тул тайлагнах боломжгүй) боловсруулж хүргүүлсэн. Мөн түүнчлэн Teams платформ дээр нэгжийн даргаас "Assign" хийж хянуулахаар иргүүлсэн албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан болно. /Нийт 15 албан бичгийн төсөл/ - НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)-ийн Аймаг, сумдын ногоон бүсийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт (ASDIP) үзүүлж буй дэмжлэгийн талаар мэдээлэл бэлтгэж, орчуулга боловсруулсан. - | сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр"-ийн төсөлд ЭЗХЯ-наас санал боловсруулж хүргүүлсэн болно. - "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төслийг боловсруулсан /Байгуулагдах шатанд/ Эдийн засаг, хөгжлийн яамны эрх бүхий албан тушаалтнаас гарах тушаал, шийдвэрийн төслийг тухай бүр хянаад хэлтсийн даргад саналаа уламжилж ажилласан: -Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулж, төслийн хууль, эрх зүйн судалгааг хийж, тайлбар үндэслэлийн хамт нэгжийн даргад танилцуулж, батлуулсан; - Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/219 дүгээр "Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай" | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалын төслийг боловсруулж, тушаалын хавсралтууд болох албан томилолтын удирдамж, зардлын төсөв зэргийг судлан боловсруулж албажуулсан болно; - Байгууллагын холбогдох нэгжүүдийн албан хаагчдын "Гадаадад албан томилолтоор ажиллуулах тухай" тушаалын төслийг мөн тухай бүр хянаж, засвар, өөрчлөлтийг оруулсан болно. | | |
| 3 | Засгийн газрын болон яамтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална. | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлсэн хувь | Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан. | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/ | 2024 оны байдлаар МУ-ын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон: -Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдоогүй бөгөөд нэгжийн холбогдох албан хаагчдад дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилласан. Тодруулбал, "Максрөүд" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч болох шинжээч | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ц.Должинсүрэнд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилласан. -Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаануудад оролцож, дэмжлэг туслалцаа үзүүлэн оролцож байгаа болно: 1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа “Улаан Дөл” ХХК-ийн нэхэмжлэлтэй Үндэсний аудитын газарт холбогдох хэрэгт гуравдагч этгээд Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байгаа бөгөөд тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бэлтгэл ажлыг гүйцэтгэж, хариу мэтгэлцэх тайлбарын хууль, эрх зүйн судалгаа хийж, боловсруулсан болно. Тус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаа болно. 2. "Чингис Лэнд Девелопмент Групп" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эдийн засаг, хөгжлийн яамыг хамтран хариуцагчаар татан оролцуулахаар заасан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байх тул шинжээч Ц.Должинсүрэн болон миний бие итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон тус хэргийн шүүх хуралд оролцохоор удирдлагаас чиглэл авч, хэргийн материалтай танилцаж, хариу тайлбар боловсруулж, шүүх хуралд хамтран оролцохоор бүхий л бэлтгэл ажлыг гүйцэтгэж, шүүх хуралд оролцсон болно. Шүүхээс "Чингис Лэнд Девелопмент Групп" ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн болно. 3."Алтай Трест" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчид дэмжлэг үзүүлэх байдлаар оролцсон болно. 4.Бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгжийн холбогдох албан хаагчдад дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллаж байна. | | |
| 4 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг | Хуулийн хугацаанд мэдүүлсэн | 2023 онд албан хаагчид 100 хувь мэдүүлсэн. | Хуулийн хугацаанд нийт албан хаагчид | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | байх, хувиар | | мэдүүлсэн байна. /100 хувь/ | ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг тухай бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилласан. Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолтууд болох албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглох тухай болон албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтын талаар мэдээлсэн. Мөн түүнчлэн байгууллагын удирдах албан тушаалтнуудад тус хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан болно.<br>Тайлант хугацаанд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн аливаа нэгэн зөрчил гаргаагүй болно. | сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 5 | Долоо хоног бүрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд ЭЗХЯ-наас | Хэрэгжилтийн явц, хувиар | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг тухай | 2023 оны III-IV улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | 2024 оны байдлаар нийт 31 Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг болон ЭЗХЯ-наас өгсөн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 100% |

162

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлсэн саналуудын жагсаалтыг нэгтгэн боловсруулна. | | бүр гаргасан. | асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан байна. /100 хувь/ | саналыг нэгтгэн Төрийн нарийн бичгийн дарга болон Сайдад тухай бүр хүргүүлсэн болно. Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны I-IV улирлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын болон намрын ээлжит чуулганаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төслийн мэдээллийг байгууллагын нэгж бүрээс саналыг нь авч нэгтгэн боловсруулж, хүргүүлсэн болно. | сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 6 | Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэнэ. | Хэрэгжилтийн явц, хувиар | Гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн. | Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. /100 хувь/ | 2024 оны байдлаар яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг боловсруулж, хянаж, нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно: - 2024 оны Гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн бөгөөд 2023 онд байгуулагдсан гэрээнүүдийг цэгцлэн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | архивын нэгж үүсгэх ажиллагаанд холбогдох албан хаагчид дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан -Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны тушаалаар дагуу байгуулагдсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 7 гэрээнд холбогдох агуулгаар /өөрсдөөс үл шалтгаалах асуудлаар хугацаа дууссантай холбогдуулан/ талуудтай харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, тус гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, боловсруулж, хэрэгжилтийг хангуулсан болно. -Оюутан ажиллуулахад хамтран ажиллах гэрээний төсөл (ХОНБЗГ, ХНБТГ) -Чөлөөт худалдааны хэлэлцээр орчуулах тухай Нууц хадгалах, хамгаалах тухай баталгааны гэрээний төсөл (ЭЗХАХНБГ) -Оюутан болон албан байгууллага хоорондын сургалтын гэрээний төсөл (МЭЗБГ, ХОНБЗГ, ХНБТГ, ТЗУГ) - Зөвлөх үйлчилгээний гэрээ (Зөвлөх ажиллуулах | | |

292

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай) (ХОНБЗГ, ХНБТГ, ЭЗХАХНБГ, МЭЗБГ) -Далдагын оюутан дадлагажуулах гэрээний төсөл (ХОНБЗГ, ТЗУГ) -Үйлчилгээ үзүүлэх гэрээний төслүүд (Агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх, Орчуулгын үйлчилгээ үзүүлэх, яамны автомашин засвар, үйлчилгээ үзүүлэх гэрээ г.м.) -Заалны түрээсийн гэрээний төслүүд -Ажил гүйцэтгэх гэрээний төслүүд -Худалдах, худалдан авах гэрээний төслүүдийг тус тус боловруулж, хянаж, засвар өөрчлөлтийг оруулж байгуулсан болно. Мөн түүнчлэн гэрээ байгуулахтай холбоотойгоор хурал, уулзалтыг зохион байгуулж, хурлын протокол тухай бүр хөтөлж, удирдлагад танилцуулж байсан болно. | | |
| 7 | Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, яамны нэгжүүдийг авлигын | Хэрэгжилтийн явц, хувиар | Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, албан хаагчдыг сургалтад хамруулсан. | Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргах, албан хаагчдыг сургалтад хамруулах /100 | Байгууллагын эрх бүхий албан тушаалтан Б.Билгүүннаранд авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргахад туслалцаа үзүүлж, "Авлига, ашиг сонирхлын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эсрэг мэдээллээр хангана. | | | хувь/ | зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт, семинарыг хамтран зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн чиглэлээр нийт албан хаагчдыг хамруулсан болно. | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 8 | Нууцын асуудлыг эрхлэн хөтөлнө | Хэрэгжилтийн явц, хувиар | Тухай бүр хөтөлсөн. | Тухай бүр хөтөлсөн байна. /100 хувь/ | Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хамгаалах, архивлахтай холбоотой ажиллагааг 1, 2 дугаар саруудад бүрэн хэрэгжүүлсэн буюу 2023 оны нууц албан бичгүүдэд архивын нэгж үүсгэж, хөтлөн, 2024 онд ирүүлсэн болон хүргүүлсэн нууц албан бичгүүдийг нууц хамгаалах тусгай хамгаалалтын сейфэнд тухай бүр бүртгэл үүсгэн хадгалсан болно. Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хамгаалах, боловсруулахтай холбогдох ажиллагааг шуурхай, тасралтгүй цаг тухайд нь хэрэгжүүлсэн болно. Тайлант хугацаанд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн аливаа нэгэн зөрчил гаргаагүй болно. Яамны бүтэц, стратеги, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төрийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

203

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагчдын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, ЭБАТ-ны жагсаалтыг шинэчлэн Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж батлуулсан болно. Мөн түүнчлэн Тагнуулын ерөнхий газар болон ЗГХЭГ-тай төрийн нууцад хамаарах гэрээний асуудлаар ТЭЗҮ-ний гэрээний холбогдох бүхий л үйл ажиллагааг үе шаттайгаар нь хариуцан гүйцэтгэсэн болно. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон | Сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон | 2024 оны байдлаар дараах хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ахисан түвшин дээшлүүлэх сургалт, семинарт оролцсон | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | оролцсон байх | байна | байна. /100 хувь/ | болно: 1. "Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хунан олон улсын бизнесийн мэргэжлийн коллежийн зохион байгуулсан Монгол дахь Бизнесийн түвшний сургалт" сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалт; 2. Хуульчдын холбоо болон Улсын Дээд Шүүхээс хамтран зохион байгуулсан "Захиргааны эрх зүйн тусгай ангийн хөгжилд хуульчдын оролцоо" сэдэвт сургалт, семинар; 3. Хууль зүйн Үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан "Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем буюу www.legalinfo.mn цахим хуудсанд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл оруулах, иргэд олон нийтээс ирүүлсэн саналын дэлгэрэнгүй тайлан мэдээг гарган авах, цахим хэлэлцүүлэг зохион байгуулах чиг үүргийг хариуцах албан хаагчдад зориулсан сургалт"; 4. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан "Хууль тогтоомжийн төсөл, захиргааны хэм хэмжээний актын төсөл болон бодлогын баримт бичиг боловсруулахад анхаарах асуудал" сэдэвт сургалт; 5. Улсын Их Хурлын Тамгын газар, Ханнс-Зайделийн сангийн хамтран зохион байгуулсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар үнэлгээ хийх аргачлал" сэдэвт сургалт; 6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран зохион байгуулсан Төрийн албыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулж буй "Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт цахим, танхим хосолсон сургалт; 7. Удирдлагын академиас зохион байгуулж буй Төрийн албанд анх томилогдон албан хаагчийг чиглүүлэх сургалт; 8. Төрийн захиргааны удирдлагын газраас зохион байгуулж буй Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлэх танхимын сургалтад идэвхтэй хамрагдаж эхний шатыг дүүргэж Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тогтоох шалгалтад хамрагдаж, тэнцсэн болно. Тус сургалт 3, 4 дүгээр улиралд үргэлжлээгүй болно. | | |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна. /100 хувь/ | 2024 оны байдлаар яамнаас зохион байгуулсан дараах мэдээллийн цагийн сургалт, семинарт тогтмол хамрагдсан болно: 1. "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалт, семинар; 2. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль" сэдэвт сургалт; 3. 2024 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-ийн хүрээнд зохион байгуулсан сургалт; 4. Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цолтой дипломатч Г.Луузангийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Дипломат ёслол” сэдэвт сургалт; 5. "Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал" сэдэвт сургалт; 6. "Захиргааны хэм хэмжээний акт, түүний хэрэгжилт /Тулгамдаж буй асуудал/" сэдэвт сургалт; 7. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)" сэдэвт сургалт; 8. "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" сэдэвт сургалт; 9. "Ус усны нөөц ирээдүй" сэдэвт сургалт; 10. “Эгийн голын усан цахилгаан станцын тухай” сэдэвт сургалтад тус тус хамрагдсан болно. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Хишигбаатар Саруул /............................................................/ Огноо: .........................